



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№65 /279/

2022.04.04

Цаг үе, үйл явдал

ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг нар Цэргийн гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт, хурандаа генерал Ж.Ёндонгийн нэрэмжит Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн үйл ажиллагаатай өнгөрсөн баасан гарагт танилцлаа.

ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзоригийг Хүндэт харуул хүндэтгэн угтаж, үүний дараа тус ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр танилцуулга хийлээ. Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр танилцуулгадаа ангийн түүх, дайчин замнал, өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг онцолж, ЗХЖШ-ын

дарга, удирдлагад уламжлах саналын талаар илтгэв. Мөн энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг Ангийн штаб, Соёлын төв, Дайчин алдрын танхим, Цэргийн цагдаагийн рот, Цайны газар, Цэргийн гал тогоо, Цэргийн байр зэрэг байр, объектуудаар явж, тус ангийн өнөөгийн байдалтай биечлэн танилцлаа. Үүний дараа ЗХЖШ-ын дарга

дэслэгч генерал Д.Ганзориг тус ангийн байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчидтай тус тусад нь уулзаж, Зэвсэгт хүчинд өрнөж буй үйл явдал, ололт амжилт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, тэдний сонирхсон асуултад хариулт өгсний зэрэгцээ санал сэтгэгдлийг нь сонсох, цаашид зарим асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцсон юм.



ЗАСМАЛ ЗАМЫН ДУГУЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТАМИРЧДАА УГТАН АВЛАА



Засмал замын дугуйн 2022 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн Тажикстан улсын нийслэл Душанбе хотод өнгөрсөн сарын 25-29 ний амжилттай зохион байгуулагдлаа. Тус засмал замын дугуйн ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ С.Жамбалжамц, ОУХМ Б.Тэгшбаяр, "Тийн огги" клубийн тамирчин ОУХМ Б.Марал-Эрдэнэ, ОУХМ Э.Билгүүнжаргал нар Монгол Улсаа төлөөлөл амжилттай оролцон мөнгөн медаль хүрсэн юм. Баг тамирчид өнгөрсөн бямба гарагт эх орондоо ирсэн бөгөөд

"Алдар" спорт хорооны орлогч дарга хурандаа В.Гомбожав, албаны дарга хошууч Д.Цэрэнбат, захиргааны удирдлагын тасгийн дарга ахмад Н.Отгонбаатар, дугуйн багш ахлах дэслэгч Н.Төгөлдөр нар угтан авч баяр хүргэлээ. Тус тэмцээний насанд хүрэгчдийн эмэгтэйчүүдийн ганцаарчилсан цуваа гараатай 24км уралдаанд Ази тивийн шилдэг 11 орны тамирчид өрсөлдсөнөөс, БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ Ц.Солонго хүрэл медалийн эзэн болсон юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,439 /69.9%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,613 /66.8%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,032,876 31,7% 115,185 /3,5%!
НИЙТ БАТЛАГДСАН 8435 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 3	ЭДГЭРСЭН 8311

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 491,756,539

Эдгэрсэн
Нийт: 426,546,216

Нас барсан
Нийт: 6,176,157

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 10	☁️ -10
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 42	☁️ 27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,010.00	3,030.0
EUR 🇪🇺	3,570.0	3,620.0
CNY 🇨🇳	493.00	498.00
RUB 🇷🇺	37.30	38.30
JPY 🇯🇵	27.00	28.00
KRW 🇰🇷	2.66	2.70

ЗУРХАЙ

2022.04.04 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 3/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх:
06.25-19.25
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй
Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойшоо мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, малтай баялаг төгс болно.

ЗҮҮЛ САРУУЛ ХАРАГДАЖ БАЙГАА ХҮН ХДХВ-ИЙН ХАЛДВАРТАЙ БАЙЖ БОЛНО.

ЯМАРЧ ӨВЧИН ТУССАН БОЛ ХУВЬ ХҮНИЙ НУУЦ, ХЭН Ч ТҮҮНИЙГ ЗАДРУУЛАХ ЭРХҮЙ. БАС ӨВЧИН ТУССАНЫ ТӨЛӨӨ ХҮНИЙГ ЭЛДВЭЭР ГУТААН ДОРМЖЛОХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЖ БОЛОХГҮЙ. ХДХВ/ДОХ-ТОЙ ХҮМҮҮСТ УДААН АМЬДРАХ БОЛОМЖ БАЙНА. ХАРИН ГУТААН ДОРМЖЛОЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ НЬ ЦАГ АЛДАЛГУЙ ЭМЧИЛГЭЭ АВАХАД СМД БОЛДОГ.

Цахим шууданд


“БИД ЦЭРГИЙН ХҮҮ” СЭДЭВТ ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН АМЖИЛТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨВ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Бид цэргийн хүү” сэдэвт цогцолбор тэмцээнийг зохион байгуулан явууллаа.

Шинэжинст сумын Х.Нямсүрэн ахлагчтай баг, дэд байранд Жаргалант сумын Б.Жадамба ахлагчтай баг, гутгаар байранд Өлзийт сумын С.Нарантэнгэр ахлагчтай багийн хамт олон тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Тус тэмцээн нь ирэх 5 дугаар 9-ны өдөр болох “Жагсаалын үзүүлэх тоглолт”, 29,30-ний өдрүүдэд зохион байгуулагдах аймгийн Засаг даргын нэрэмжит “Дөл-2022” тэмцээний эхний шатууд болж өгч байгаагаараа онцлогтой юм.



ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН I УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ



ЦДБЭЧ-ын хамт олон 2022 оны I улиралд хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэн хэлэлцэж, тайлангийн хурлаа зохион байгууллаа.

Түүхт 90 жилийн ойг угтан зохион байгуулсан томоохон тоглолт уран бүтээлүүд, улсын чанартай тэмцээн, наадам, соёлын ажлууд болон аж ахуй, тохижилт үйлчилгээний ажлуудыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна. Чуулга 2022 оны I улиралд

нийт 202 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 92,4 хувьтай хэрэгжсэн байна. Улирлын ажлаа дүгнэж хэлэлцсэний дараагаар “Улирлын ажлын дүн”-г чуулгын даргын тушаалаар баталгаажууллаа.



Е.Шарав: ИНЖЕНЕРИЙН ЦЭРГЭЭР ОВОГЛОСОН АХМАД ДАЙЧИН ГЭДГЭЭРЭЭ ҮРГЭЛЖ БАХАРХАЖ, ОМОГШИЖ ЯВДАГ ДАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Тус ангид 3 жилийн хугацаат цэргийн алба хаасан бэлтгэл ахлах байлдагч Е.Шарав хүрэлцэн ирсэн юм. Тэрээр ангийн ХЦАХ-тай уулзалт зохион байгуулж 3 жилийн цэргийн алба хаах хугацаанд эзэмшсэн туршлага, сургаж болон сонирхолтой дурсамжаа хуваалцлаа.

Бэлтгэл ахлах байлдагч Е.Шарав хэлэхдээ “Миний бие бэлтгэл ахлах байлдагч Е.Шарав 1967-1970 онд Инженерийн тусгай батальонд 3 жилийн цэргийн алба хаасан юм. Одоогийн Зэвсэгт хүчний 014 дүгээр анги Улиастайд байх үеийн захирагч хошууч Д.Дандар байлаа. Удаах захирагчаар хурандаа Төмөртөгоо ажиллаж байсан юм. Манай ангийн дайчид улиастайн гол үерлэхэд маш олон хүний амь аварсан их баатарлаг түүхтэй. Тус ангид цэргийн 3 жилийн алба хаасан гэдгээрээ их бахархаж, омогшиж явдаг даа. Бид 3 жилийн хугацаанд цэргийн эрдэмд шамдан суралцаж, сахилга, дэг журмыг чандлан сахиж, захирах, захирагдах ёсыг эрхэмлэн дээдлэж, тэсвэр хатуужилтай, эмх цэгцтэй, нөхөрлөлдөө үнэнч

байх зэрэг эрхэм чанарыг төгс эзэмшин, нэг хүн шиг цул болсон юм. Марш тактикийн тэмцээнд гараанаас гараад замын дундах бүх ажиллагааг хүн нэг бүр чанартай биелүүлж нэг ч хүн орхилгүй барианд ордог ийм л чадварлаг дайчид болсон доо. Энэ ч утгаараа 3 жил алба хаах хугацаанд Армийн марш тактикийн тэмцээнд тэргүүн 5-д жагсдаг байсан юм.

Цэргийн алба хаасан хүн бүрийн зүрх сэтгэлд насан туршид нь хадгалагдаж үлддэг хамгийн нандин дурсамж бол он жавуудтайгаа өнгөрүүлсэн цаг хугацаа хором, мөч тэр дундаа жаргал, зовлонгоо хамтдаа туулах үед сэтгэлд үлдсэн дурсамж байдаг юм. Цэргийн албанаас сурсан эрдэм мэдлэг халагдсан хоино ч ажил, амьдралд сайнаар

нөлөөлж мөрдөх хэв, зуршил хэм хэмжээ болдог юм билээ. Ахмад дайчин миний зүгээс та бүхэнд хандаж амьдралын хатууд нугардаггүй, аливаа бэрхшээлд шантардаггүй, оюун санааны болон бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй болж хугацаат цэргийн албаа нэр төртэй хаахыг онцгойлон захиж байна.

Мөн эрхэм түрүүч, байлдагчид та бүхэнд Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчний түүхт 101 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, Монгол төрийн сүлд хийморь өнө мөнхөд ивээж явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлбэ” гэлээ.

Уулзалтын төгсгөлд ЗХ-ний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагчдад хандан “Морин хуур бол монгол угсаатны соёл, зан заншлын уламжлалыг цогц байдлаар агуулж буй хөгжмийн зэмсэг билээ эрхэм дайчид та бүхэн эрхэмлэн дээдлэж яваарай” гээд Морин хуур хөгжмийг бэлэг болгон бариллаа.

Үүний дараа ангийн удирдлагын зүгээс ахмад дайчин, бэлтгэл ахлах байлдагч Е.Шаравт баярласан, талархсанаа илэрхийлж дурсгалын зүйл гардуулав.

Дэслэгч Р.БИЛЭГ





Ажилд урьж байна

БХЯ-ны “Соёмбо” редакц дараах ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтад урьж байна. Үүнд:

- Зураглаач-эвлүүлэгч
- Тавигдах шаардлага: Мэргэжлийн үнэмлэхтэй, 35 хүртэлх настай, мэргэжлийн дадлага, туршлагатай, офицерын албанд орж ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх,
- Гэрэл зурагчин
- Тавигдах шаардлага: Мэргэжлийн үнэмлэхтэй, 35 хүртэлх настай, мэргэжлийн дадлага, туршлагатай, хэвлэлийн эх бэлтгэл, дизайны программууд дээр ажиллах чадвартай, ахлагчийн албанд орж ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх.

Холбоо барих утас: 88109945, 99224435



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)